

САНХҮҮГИЙН ХЭРЭГСЛҮҮД БОЛОН ХУРИМТЛУУЛЖ ТООЦСОН ХҮҮНИЙ АВЛАГА, ӨГЛӨГТ СЕКТОРЫН АНГИЛАЛ ХИЙХ ЗААВАР

Уг заавар нь Мөнгө санхүүгийн статистикийн гарын авлагад тусгагдсан санхүүгийн хэрэгслүүдийн секторын ангилалтай нийцэж байгаа болно. Секторын ангиллаар санхүүгийн хэрэгслүүдийг ангилах нь мөнгөний бодлогын шийдвэр гаргалт, эдийн засгийн судалгаа шинжилгээ, мөнгөний статистикийн нэгтгэлд чухал үүрэгтэй байдаг.

1. Эдийн засгийн харьяат¹

Харилцагчийн эдийн засгийн харьяатыг тогтоохдоо түүний үндэс угсаа, байгаа мөнгөний нэгж зэргээс илүү эдийн засгийн сонирхлын төв²-ийг харгалзан үзнэ.

Эдийн засгийн харьяат (оршин суугч) гэж Монгол улсын нутаг дэвсгэр дээр оршин сууж байгаа Монгол улсын иргэд, гадаад оронд 1 жил хүртэлх хугацаагаар түр оршин сууж байгаа Монгол улсын иргэд, Монгол улсын нутаг дэвсгэр дээр 1 жилээс дээш хугацаагаар оршин сууж байгаа гадаадын иргэд, Монгол улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага, тэдгээрийн салбар, төлөөлөгчийн газар, Монгол улсаас гадаад орнуудад суугаа элчин сайдын яам, консулын болон байнгын төлөөлөгчдийн газар, тэдгээрт ажилладаг Монгол улсын иргэд, цэргийн албан хаагч гэр бүлийн гишүүдийн хамт, гадаад оронд сурч байгаа болон гадаадад урт, богино хугацаагаар эмчлүүлж байгаа Монгол улсын иргэдийг тооцно.

Эдийн засгийн харьяат бус (оршин суугч бус)-г эдийн засгийн харьяатаас бусад гадаад орны болон Монгол улсын иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудыг тооцно. Банкуудын тайланд гадаадын банк, оршин суугч бус гэсэн ангиллаар харуулсан болно.

2. Секторын ангилал

Эдийн засгийн харьяат байгууллагуудыг секторын ангиллаар зөв ангилан, тэдгээрийн эзэмшиж буй санхүүгийн хэрэгслүүд, хуримтлуулж тооцсон хүүний авлага, өглөгийг тухайн секторт задалж өгөх шаардлагатай байдаг. Олон улсын стандартаар эдийн засгийн харьяат байгууллагуудыг (1) Санхүүгийн байгууллага, (2) Санхүүгийн бус байгууллага, (3) Засгийн газар, (4) Өрх гэр, (5) Өрх гэр, иргэдэд үйлчлэгч ашгийн бус байгууллага гэж ангилдаг. Тухайн байгууллага нь олон үйл ажиллагаа эрхэлдэг бол зонхилох үйл ажиллагаа эрхэлж байгаагаар нь ангилна.

Санхүүгийн байгууллага нь Төв банк, хадгаламжийн байгууллага, бусад санхүүгийн байгууллагаас бүрдэнэ.

Хадгаламжийн байгууллага

Хадгаламжийн байгууллагад харилцах, хадгаламж хэлбэрээр хөрөнгө татдаг болон эсвэл эх үүсвэр нь харилцах, хадгаламжийг орлуулж болох эх үүсвэр татдаг санхүүгийн байгууллагуудыг хамруулдаг. Манай улсын хувьд арилжааны банкууд, хадгаламж зээлийн

¹ Монгол Улсын төлбөрийн тэнцлийг боловсруулах аргачлалтай нийцэж байгаа болно.

² Эдийн засгийн сонирхлын төвтэй гэж тухайн субъект эдийн засгийн нутаг дэвсгэр дээр орон сууц, үйлдвэр, үйлчилгээний газар, байгууламж зэргийг өмчилдөг, эрдэс баялгийн нөөц ашиглаж, орлого олох, бусад үйл ажиллагаа явуулж байгааг хэлнэ.

хоршоодыг хамруулж байна. Банкуудын тайланд банк, хадгаламж зээлийн хоршоо гэсэн ангиллаар харуулсан болно.

Бусад санхүүгийн байгууллага

Төв банк, хадгаламжийн байгууллагаас бусад санхүүгийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагуудыг оруулах бөгөөд манай орны хувьд банк бус санхүүгийн байгууллага, үнэт цаасны компани, даатгалын компани (гэхдээ НДЕГ³ Засгийн газрын харъяа байгууллага тул энд хамрагдахгүй) зэрэг санхүүгийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагууд хамрагдана.

Санхүүгийн бус байгууллага нь санхүүгийн бус үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлдэг улсын болон хувийн хэвшлийн байгууллагууд юм.

Улсын байгууллага (санхүүгийн бус)

Санхүүгийн бус үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлдэг Засгийн газрын харъяа байгууллагыг хамруулдаг. Засгийн газрын харъяа гэдгийг удирдлагыг чөлөөлөх, томилох зэргээр байгууллагын ерөнхий удирдлагад зохицуулт хийхийг хэлнэ. Тухайн байгууллагын өмчийн 50-аас дээш хувийг төр эзэмшдэг бол тус секторт хамруулна. Төрийн өмчийн үйлдвэрийн газрууд, улсын их дээд сургуулиудыг хамруулна.

Хувийн байгууллага (санхүүгийн бус)

Засгийн газрын харъяа бус бусад бүх санхүүгийн бус үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч байгууллагуудыг хамруулна. Гол хяналтыг авч байгаа байдлаар, өөрөөр хэлбэл өмчийн 50-аас дээш хувь хувийн өмчлөлтэй бол тус секторт хамруулна. Банкуудын тайланд хувийн хэвшил гэсэн ангиллаар харуулсан болно.

Засгийн газар

Яамдууд, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагууд, Татварын ерөнхий газар, Улсын гаалийн ерөнхий газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, тэдгээрийн харъяа хэлтсүүд, дунд сургууль, цэцэрлэг болон бусад улсын төсвийн байгууллагуудыг багтаасан том хэмжээний цогц сектор юм. Улсын төсвийн байгууллагууд төсвөөс тодорхой хувиар санхүүждэг эсвэл тухай оны төсвийн тухай хуульд тусгагдсан байгууллагуудыг хамруулдаг.

Өрх гэр

Өрх гэр нь хэсэг бүлэг хүмүүс нэг байр сууцанд амьдарч, орлого, зарлагаа нэгтгэн зарцуулдаг. Өрх гэрийн секторыг банкуудын тайланд иргэд гэсэн ангиллаар харуулсан болно.

Өрх гэр, иргэдэд үйлчлэгч ашгийн бус байгууллагууд

Төлбөргүй эсвэл бага хэмжээний хураамж бүхий зах зээлийн бус бүтээгдэхүүн, үйлчилгээг өрх гэр, иргэдэд үзүүлдэг ашгийн бус байгууллагууд юм. Ашгийн бус байгууллагууд нь тусламжаар, гишүүдийн хураамжаар санхүүждэг бөгөөд тэдгээрт худалдааны нэгдэл, мэргэжсэн нийгэмлэгүүд, хэрэглэгчдийг хамгаалах нийгэмлэг, улс төрийн намууд, сүм, хийдүүд, нийгэм, соёл, спортын клуб зэрэг орно. Мөн бусад байгууллагуудаас сайн дураар санхүүжигдсэн хүмүүнлэгийн тусламжийн байгууллагууд орно. Харин хувийн сургууль, цэцэрлэг⁴ орохгүй. Банкуудын тайланд эдгээр ашгийн бус байгууллагыг бусад гэсэн ангиллаар харуулсан болно.

³ НДЕГ нь Засгийн газрын бүлэгт хамрагдана.

⁴ Хувийн хэвшлийн байгууллагад хамруулна.